

## ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагуудын 2023 оны үйл ажиллагааны үр дүнд “Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал”-ын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангаас мэдээлэв.

### ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖ, ДЭРГЭДЭХ БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНЭЛГЭЭ

Гаалийн ерөнхий газрын нэгжүүдийн 2023 оны үйл ажиллагааг нийт 248 шалгуур үзүүлэлтийн биелэлтийн дундаж үнэлгээ **86.25** оноотой “**В**” буюу “**Сайн**” үнэлгээтэй байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгээр нийтлэг болон тусгайлсан 76 зөвлөмж хүргүүлээ.

Д/д	Эрэмбэ	Нэрс	Дүн
1	ГАЗАР	Захиргааны удирдлагын газар	90.0
2		Зөрчилтэй тэмцэх, аюулгүй байдлын газар	91.3
3		Санхүү, хөрөнгө оруулалтын газар	89.7
4		Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	90.5
5		Хяналт, бүрдүүлэлтийн газар	91.0
6		Тариф, татварын газар	89.5
7	ХЭЛТЭС	Хүний нөөцийн хэлтэс	91.0
8		Хуулийн хэлтэс	85.5
9		Гадаад хамтын ажиллагааны хэлтэс	84.5
10		Дотоод хяналт, шалгалтын хэлтэс	78.5
11		Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтэс	89.5
10		Боомтын хөгжлийн хэлтэс	83.0
13		Эрсдэлийн удирдлагын хэлтэс	84.8
14		Хорио цээрийн хэлтэс	77.8
15		Барааны ангилал, үнэлгээний хэлтэс	80.9
16		Статистик, дүн шинжилгээний хэлтэс	89.9
17	ДЭРГЭДЭХ	Сургалтын төв	83.8
18		Олон нийттэй харилцах алба	84.0
19		Инженер техник, аж ахуй үйлчилгээний алба	84.6
20		Хяналтын нэгдсэн төв	84.0
21		Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газар	88.1
22		Мэдээллийн технологийн газар	86.0
23		Эрэлч нохойн сургалтын төв	85.0
24		Гаалийн төв лаборатори	87.0
<b>Дундаж үнэлгээ</b>			<b>86.25</b>

## **НИЙТЛЭГ ЗӨВЛӨМЖӨӨС:**

1. Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага тус бүр “Гаалийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө”-ний арга хэмжээнээс чиг үүргийнхээ хүрээнд 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа зорилтот түвшинг тодорхой, бодитой төлөвлөхөд анхаарах;
2. Олон нэгж хамтран хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр арга хэмжээний биелэлтийг тайлагнаж ирүүлэхгүй орхигдуулах тохиолдолд гарч байгаад анхаарч, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд хэрэгжүүлж буй арга хэмжээний уялдааг хангаж тайлагнах;
3. Тайлант хугацаанд нэгжүүдийн албан хаагчдаас “Ажлын хэсэг”-т орж ажилласан арга хэмжээний хэрэгжилтийг болон аливаа гадаад, дотоодын төсөл хөтөлбөрийн биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж цаашид өөрийн нэгжийн “Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад ажил” шалгуурт тайлагнаж хэвших;
4. ГЕГ-ын ЗББНДБ-уудаас харьяа гаалийн газар, хороодод ЗДАС-ийн “Үүрэг даалгавар”-ын программаар өгч буй үүрэг даалгаврын биелэлтийг хугацаандаа оруулж буй эсэхэд тогтмол хяналт тавьж, бодитой үнэлэх, биелэлт хангалтгүй тохиолдолд биелэгдэх хүртэл нь дахин өгч хяналт тавьж ажиллах;
5. Бодлогын бичиг баримт, хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийн үр дүнг үнэлүүлэхтэй холбоотой мэдээ, тайланг Захиргааны удирдлагын газарт хугацаанд нь үнэн зөв гаргаж өгөх, дутуу, буруу тайлагнахгүй байхад анхаарах;
6. Дээрх хэрэгжилтийг тайлагнахын тулд ГЕГ-ын ЗББНДБ-ууд өөрийн чиг үүрэгт хамаарах эрх зүйн актын жагсаалтыг гаргаж, бие даан болон хамтран хэрэгжүүлэх нэгж зэрэг байдлаар төрөлжүүлж ангилан хэрэгжилтийг гаргаж хэвших;
7. Чиг үүргийн нэгжүүд эрсдэлийн онилгоог ихэвчлэн ачаатай импортын тээврийн хэрэгсэлд хийж байгааг төрөлжүүлж, экспортын бараа, шуудан илгээмж, зорчигч, түүний орох, гарах чиглэл, тээвэрлэгч, магадлан шинжилгээ, гаалийн үнэлгээ, барааны ангилал, гаалийн зуучлагч зэргээр шалгуурыг өргөжүүлэхэд анхаарах;
8. Нэгжийн удаашралтай буюу дутуу хэрэгжсэн, хэрэгжээгүй арга хэмжээг биелүүлэхэд анхаарч ажиллах.

**ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

